



МОНГОЛ УЛС  
ТӨВ АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2016 оны 01 сарын 22-дөрөн

Дугаар A/01

Зуунмод

Орон тооны бус байнгын комисс  
томилох тухай

“Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.2, Засгийн газрын 2015 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 269 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”-ийн 1.8, 3.1, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны Б/99 дүгээр тушаалаар батлагдсан “Байгууллагын даргын тушаал гаргах журам” /код 136/-ын 136.4.2 “е”, 136.5.2 “а”, 2015 оны А/79 дүгээр тушаалаар баталсан “Албан үүргээ гүйцэтгэж байхдаа гэмтэж бэртсэн, осолд өртсөн алба хаагчийг бүртгэх журам” /код 929/-ын 929.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- Цагдаагийн газрын хэмжээнд “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх үүрэг бүхий орон тооны бус байнгын комисс”-ыг хавсралтад заагдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.
- “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль”, “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”, “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам”-ын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж, үйлдвэрийн осол, хурц хордлогын улмаас амь нас, эрүүл мэндээрээ хохирсон алба хаагчдад холбогдох хууль, тогтоомжийн дагуу дэмжлэг туслалцаа үзүүлэн ажиллаж, ажлын тайлан, мэдээг улирал тутам гаргаж танилцуулан, Цагдаагийн ерөнхий газрын “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комисс”-т хүргүүлэн ажиллахыг комиссын даргад үүрэг болгосугай.
- Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төлөвлөлт, зохион байгуулалтын тасгийн дарга /цагдаагийн хошууч Б.Анхбаатар/-д үүрэг болгосугай.
- Тушаалыг бие бүрэлдэхүүнд танилцуулсугай.

ДАРГА,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

А.БАТБАЯР

Tushaal

45000013

Цагдаагийн газрын даргын .....  
оны ..... дугаар сарын .....-ны өдрийн  
..... тоот тушаалын хавсралт

## ОРОН ТООНЫ БУС БАЙНГЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

- |                       |  |
|-----------------------|--|
| Комиссын дарга:       | -Төлөвлөлт, зохион байгуулалтын тасгийн дарга  |
| Нарийн бичгийн дарга: | -Ахлах нягтлан бодогч  |
| Гишүүд:               | <ul style="list-style-type: none"><li>-Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасгийн дарга,</li><li>-Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга,</li><li>-Замын цагдаагийн тасгийн дарга.</li></ul> |

## ЦАГДААГИЙН ГАЗАР